



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар A/93

Улаанбаатар хот

«Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн барааны тэмдгийг ашиглах журмыг батлах тухай»

Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3, 13 дугаар зүйл, 17 дугаар зүйл, ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. «Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн барааны тэмдэг ашиглах журам»-ыг хавсралтаар баталсугай.
2. «Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн барааны тэмдэг ашиглах журам»-ыг нийт багш, ажилтан, суралцагчдад танилцуулах, мөрдөж хэрэгжүүлэхийг бүрэлдэхүүн сургууль, газар, алба нэгжүүдийн захирал, дарга нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалыг 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Технологи дамжуулах төвийн захирал (Т.Ганбаатар) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т. НАМНАН

367040402



	ШУТИС-ИЙН БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ ЖУРАМ ШУТИС-ЭШ-ЖУ03	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2022.03.01 - 0
---	--	--	----------------------

ШУТИС-ИЙН БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

Боловсруулсан:

ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ ТӨВ

Хянасан:

ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	4
ЗУРГАА. БАРААНЫ ТЭМДГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ.....	5
ДОЛОО. БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ, АШИГЛУУЛАХ.....	5
НАЙМ. БАРААНЫ ТЭМДГИЙН АШИГЛАЛТААС ОЛСОН ОРЛОГО, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ	6
ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	7
ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ	8



НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС) болон түүний нэгжүүд бараа, үйлчилгээгээ бусад байгууллага, хуулийн этгээдийн бараа үйлчилгээнээс ялгах зорилгоор барааны тэмдэг ашиглана.
- Энэхүү журам нь ШУТИС-ийн дангаараа эсвэл хамтран эзэмшдэг барааны тэмдгийг ашиглах, ашиглуулах эрхийг хамгаалах талаарх харилцааг зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, ахисан түвшний сургууль, технологийн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ахлах сургууль, сургалт, судалгааны хүрээлэн, төв, гарааны компани, лаборатори, номын сан болон нийт суралцагчдын үйл ажиллагаанд хамаарна.
- ШУТИС-ийн барааны тэмдгийг сонирхогч хувь хүн, хуулийн этгээд

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- Оюуны өмчийн тухай хууль;
- Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль;
- “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө;
- ШУТИС-ийн дүрэм;
- ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм
- ШУТИС-ийн технологи дамжуулах журам

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Барааны тэмдэг гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэж илэрхийллийг;
- Барааны тэмдэг эзэмшигч гэж бүртгэсэн барааны тэмдгийг өмчлөх эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээдийг;
- ШУТИС-ийн барааны тэмдэг гэж өмчлөх, ашиглах эрхийг нь хуульд заасан журмын дагуу ШУТИС-д олгосон барааны тэмдгийг;
- ШУТИС-ийн нэгж гэж ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, ахисан түвшний сургууль, технологийн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ахлах сургууль, сургалт, судалгааны хүрээлэн, төв, гарааны компани, лаборатори, сургалт үйлдвэрлэлийн дадлагын бааз, номын сан, үйлчилгээний бусад нэгж;
- Лицензийн гэрээ гэж барааны тэмдэг эзэмшигч барааны тэмдгийг бусад этгээдэд ашиглуулах тухай бичгээр байгуулсан хэлцлийг;
- Роялти гэж оюуны өмчийг лицензийн гэрээгээр ашиглан, олсон орлогоос лиценз олгогчид ногдох төлберийн хувь хэмжээг;



ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн дэд захирал
 - 5.1.1. Барааны тэмдгийг ашиглуулах тухай шийдвэр гаргах;
 - 5.1.2. Лицензийн гэрээ байгуулах хэлэлцээрт ШУТИС-ийг төлөөлөх;
- 5.2. Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны эрдмийн дэд зөвлөл
 - 5.2.1. Оюуны өмч, барааны тэмдгийн эрхийн хамгаалалт, ашиглалтын талаар зөвлөмж гаргах;
 - 5.2.2. ШУТИС-ийн барааны тэмдгийг ашигласан тухай тайлан, мэдээг Эрдмийн зөвлөлд танилцуулах;
- 5.3. Технологи дамжуулалтын асуудал эрхэлсэн нэгж
 - 5.3.1. Барааны тэмдгийн ашиглалтанд хяналт тавих, зохисгүй ашиглалтыг таслан зогсоо арга хэмжээ авах эрхтэй.
 - 5.3.2. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалттай холбоотой асуудлыг хариуцах;
 - 5.3.3. Эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийг нийтэд мэдээлэх;
 - 5.3.4. Барааны тэмдэг ашиглах хүсэлт хүлээн авах, судлан шийдвэрлүүлэх;
 - 5.3.5. Лицензийн гэрээний хэрэгжилтийг хариуцах;
 - 5.3.6. Барааны тэмдэг ашиглахтай холбоотой гомдол, маргааныг шийдвэрлүүлэх;
- 5.4. Барааны тэмдэг ашиглагч ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагч
 - 5.4.1 ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагч нь аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа, бүтээлдээ ШУТИС-ийн барааны тэмдгийг энэхүү журмын 7.3-т заасны дагуу ашиглах эрхтэй;
 - 5.4.2 ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагч нь ШУТИС-ийн барааны тэмдгийг журмын 7.3-д зааснаас бусад тохиолдолд ашиглахдаа энэхүү журмын 7.4-т заасны дагуу ашиглах үүрэгтэй.
 - 5.4.3 Онцгой эрх, зөвшөөрлийн дагуу ашиглаж буй барааны тэмдгийн зөрчил, гомдлыг шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхтэй;
- 5.5. ШУТИС-ийн барааны тэмдгийг сонирхогч хувь хүн, хуулийн этгээд
 - 5.5.1 ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагчдаас бусад хувь хүн, хуулийн этгээд аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа, бүтээлдээ ШУТИС-ийн барааны тэмдгийг зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно.
 - 5.5.2 Хувь хүн, хуулийн этгээд аливаа арга хэмжээ, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ ШУТИС-ийн барааны тэмдгийг энэхүү журмын 7.9-д зааснаар ашиглаж болно.
 - 5.5.3 Барааны тэмдгийг гэрээ болон энэхүү журамд заасны дагуу ашиглах үүрэгтэй;
 - 5.5.4 Онцгой эрх, зөвшөөрлийн дагуу ашиглаж буй барааны тэмдгийн талаарх зөрчил, гомдлыг шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхтэй;
- 5.6. Энэхүү журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Барааны тэмдэг газарзүйн заалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



ЗУРГАА. БАРААНЫ ТЭМДГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ

- 6.1. ШУТИС, түүний нэгжүүд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор барааны тэмдэг ашиглах бол барааны тэмдгийг бүртгүүлж баталгаажуулахаар гадаад, дотоодын оюуны өмчийн байгууллагад мэдүүлэг гаргаж болно.
- 6.2. ШУТИС, түүний нэгжүүдийн эзэмших барааны тэмдгийн мэдүүлгийг оюуны өмч, технологи дамжуулалтын асуудал эрхэлсэн нэгжээс боловсруулж Оюуны өмчийн газарт мэдүүлнэ.
- 6.3. ШУТИС, түүний нэгжүүд эрх бүхий байгууллагад бараа, үйлчилгээний тэмдгийг бүртгүүлэхдээ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 6.4. ШУТИС, түүний нэгжүүдийн бүртгүүлсэн бараа, үйлчилгээний тэмдгийн эзэмшигч нь ШУТИС байна.
- 6.5. Барааны тэмдгийн хүчинтэй хугацааг сунгах, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах эрх ШУТИС-д байна.
- 6.6. ШУТИС-ийн барааны тэмдгийг зөвшөөрөлгүйгээр үүсмэл бүтээл болгон өөрчлөхийг хориглоно.

ДОЛОО. БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ, АШИГЛУУЛАХ

- 7.1. ШУТИС нь эзэмшиж буй барааны тэмдгээ ашиглах, сонирхогч этгээдэд ашиглуулах онцгой эрхийг эзэмшинэ.
- 7.2. ШУТИС-ийн барааны тэмдгийг ашиглагч аливаа этгээдийг ШУТИС-ийн нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг зөрчихгүй байхыг шаардана.
- 7.3. ШУТИС, түүний нэгжүүд болон багш, ажилтан, суралцагчдын доорх үйл ажиллагаа, хэрэглээнд ШУТИС-ийн барааны тэмдгийг ашиглахыг зөвшөөрнө. Үүнд:
 - 7.3.1. ШУТИС-ийн нэгжийн албан бичиг, баримт, хэвлэмэл хуудсанд хэрэглэх
 - 7.3.2. ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагчдын, хичээл сургалтын үйл ажиллагаа
 - 7.3.3. ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагчдын үндсэн үйл ажиллагаанд хамаарах ашгийн бус хурал, семинарт цахим болон хэвлэмэл байдлаар ашиглах
 - 7.3.4. ШУТИС, түүний нэгжийн үндсэн үйл ажиллагааны зар, сурталчилгаа
 - 7.3.5. ШУТИС-ийн нэгжээс эрхлэн гаргаж байгаа танилцуулга, сэтгүүл, эрдэм шинжилгээний эмхтгэл
 - 7.3.6. Байгууллагын албан ёсны анги танхим, өрөө тасалгааны хаяг, дугаарт ашиглах
 - 7.3.7. ШУТИС-ийн багш, ажилтны нэрийн хуудас, танилцуулга
 - 7.3.8. ШУТИС, түүний нэгжийн албан ёсны вэб, цахим хуудас
 - 7.3.9. ШУТИС-ийн албан хаагчид, суралцагчдын албаны и-мэйл хаягт ашиглах
 - 7.3.10. ШУТИС-иас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа
 - 7.3.11. ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагчдын ашгийн бус спорт, урлаг, олон нийтийн арга хэмжээ



- 7.4. ШҮТИС-ийн багш, ажилтан, суралцагч нь энэхүү журмын 7.3-т зааснаас бусад хэлбэрийн үйл ажиллагаа, хэрэглээнд барааны тэмдгийг ашиглах тохиолдолд энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу ашиглана.
- 7.5. ШҮТИС-ийн багш, ажилтан, суралцагчид нь ШҮТИС-ийн барааны тэмдэг ашиглан арилжааны хэлбэрийн үйл ажиллагаа явуулсан бол барааны тэмдэг ашигласны төлбөр төлөх зарчмыг баримтална.
- 7.6. Энэхүү журмын 7.5-т заасан барааны тэмдэг ашигласан төлбөрийн хэмжээг ШҮТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж мөрдөнө.
- 7.7. ШҮТИС-ийн багш, ажилчдын хэрэгжүүлж буй төсөл, гэрээт ажлын орлогоос холбогдох журмын дагуу шимтгэл төлсөн тохиолдолд тухайн төсөл, гэрээт ажлын хувьд барааны тэмдэг ашигласны төлбөрийг тооцохгүй.
- 7.8. Энэхүү журмын 7.5-д заасан төлбөр нь ШҮТИС-ийн эзэмшлийн оюуны өмч бүхий бүтээлд хамаарахгүй.
- 7.9. ШҮТИС нь сонирхогч этгээдэд өөрийн эзэмшиж буй бараа, үйлчилгээний тэмдгийг бүх эсвэл зарим бараа, үйлчилгээний хувьд хэсэгчилсэн байдлаар лицензийн гэрээний үндсэн дээр ашиглуулна.
- 7.10. Лицензийн гэрээ сонирхогч этгээд нь барааны тэмдэг ашиглах тухай хүсэлтээ технологи дамжуулах асуудал эрхэлсэн нэгжид гаргана.
- 7.11. Барааны тэмдэгт ашиглуулах тухай лицензийн гэрээг эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал сонирхогч талтай байгуулж, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.
- 7.12. ШҮТИС нь лицензийн гэрээ байгуулсан тухай олон нийтэд мэдээлж, гэрээлэгчид онцгой эрх олгож, хамгаалах бодлого баримтална.

НАЙМ. БАРААНЫ ТЭМДГИЙН АШИГЛАЛТААС ОЛСОН ОРЛОГО, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ

- 8.1. ШҮТИС-ийн барааны тэмдгийн ашиглалтын орлого нь барааны тэмдгийг төлбөрт нөхцөлөөр болон лицензийн гэрээний дагуу ашигласан төлбөр байна.
- 8.2. ШҮТИС-ийн барааны тэмдгийн ашиглалтын орлогыг ШҮТИС-ийн судалгааг дэмжих дансанд төвлөрүүлнэ.
- 8.3. Лицензийн гэрээгээр ашиглаж буй барааны тэмдгийн ашиглалтын орлогыг ШҮТИС-ийн хүний нөөц, материаллаг баазыг дэмжихэд зарцуулж болох ба энэ тухай зохицуулалтыг гэрээнд тодорхой тусгасан байна.
- 8.4. Барааны тэмдгийн ашиглалтын төвлөрсөн орлогыг дараах үйл ажиллагаанд зарцуулна.
 - 8.4.1. Их сургуулийн эзэмших оюуны өмчийн эрхийн хамгаалалтын зардал;
 - 8.4.2. ШҮТИС-ийн барааны тэмдэг хэрэглэгч, сонирхогчдод мэдээлэл хүргэх, барааны тэмдэг таниулан сурталчлах;
 - 8.4.3. Лицензийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа;
 - 8.4.4. Эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих бусад үйл ажиллагаа;
 - 8.4.5. ШҮТИС-ийн хүний нөөц, материаллаг баазыг дэмжих үйл ажиллагаа



ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах;
[C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [I] – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)		
				ТДАХ нэгж	Эших захирал	Дэд зөвлөл
1	Мэдүүлгийн маягт	<pre> graph TD Start(()) --> S1[1. Барааны тэмдгийн мэдүүлгэг гарах] S1 --> S2[2. Хэрэглэгч сонирхогчдод мэдээлэх] S2 --> S3[3. Барааны тэмдэг төлбөртэй ашиглах хүсэлт, лицензийн гэрээ байгуулах хүсэлт гаргах] S3 --> Decision{Зөв шөөрөх эсэх} Decision --> Time[Тийм] Time --> S4[4. Гэрээг зөвшлилцэн байгуулах] S4 --> S5[5. Оюуны өмчийн газарт гэрээг бүртгүүлэх] S5 --> S6[6. Гэрээг нийтэд мэдээлэх] S6 --> S7[7. Гэрээний хэрэгжилтийг хянах] S7 --> S8[8. Гэрээг дүгнэх, хаах] S8 --> End(()) </pre>	Хамгаалсан барааны тэмдэг	R	A	I
2	Хамгаалсан барааны тэмдэг		Барааны тэмдгийн хамгаалалтын мэдээлэлтэй хэрэглэгч	R	C	I
3	Барааны тэмдгийн хэрэглэгч		Барааны тэмдэг төлбөртэйгээр ашиглауулах шийдвэр	R	A	I
4	Лицензийн гэрээний төсөл		Баталгаажсан лицензийн гэрээ гэрээний бүртгэл	R	A	I
5	Баталгаажсан лицензийн гэрээ		Оюуны өмчийн газар бүртгэлтэй лицензийн гэрээ	R	I	I
6	Бүртгэлтэй лицензийн гэрээ		Давуу эрх бүхий лицензийн гэрээ	R	I	I
7	Лиценз эзэмшигч		Барааны тэмдгийн зохицой ашиглалт	R	I	I
8	Барааны тэмдгийн орлого		Чөлөөт, дахин ашиглауулах боломжтой барааны тэмдэг	R	A	I



ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хариуцах эзэн /хадгалалт
1	ШУТИС-ийн барааны тэмдэг ашиглах хүсэлт	ЭШ-М006	Технологи дамжуулах төв
2	ШУТИС-ийн барааны тэмдгийг ашиглах лицензийн гэрээ (улгэрчилсэн загвар)	ЭШ-М007	Технологи дамжуулах төв
3	Барааны тэмдгийн хяналтын бүртгэл	ЭШ-М008	Технологи дамжуулах төв

МАЯГТ: ЭШ-М006

ШУТИС-ИЙН БАРААНЫ ТЭМДЭГ АШИГЛАХ ХҮСЭЛТ

Хүсэлт гаргасан огноо: _____

1. Барааны тэмдэг ашиглагчийн мэдээлэл:

Нэр: _____ И-мэйл хаяг: _____ Утасны дугаар: _____

ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагч эсэх: Тийм Үгүй

ШУТИС-ийн багш, ажилтан, суралцагч бол албан тушаал болон харьялалаа бичнэ үү !

“ШУТИС-ийн барааны тэмдэг ашиглах” журмыг уншиж танилцсан бөгөөд холбогдох заалтуудыг зөвшөөрч

энэхүү хүсэлтийг гаргав. Тийм Үгүй

2. Барааны тэмдэг ашиглалтын мэдээлэл:



Ашиглахаар хүсэлт гаргаж буй барааны тэмдгийн улсын бүртгэлийн дугаар:

Барааны тэмдэг ашиглах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр:

Бүтээгдэхүүний тоо ширхэг: _____

Ашиглах хугацаа: _____

Бүтээгдэхүүн, үйлчилгээний ангилал:

Хэвлэмэл материал

Хэвлэмэлээс бусад бараа, бүтээгдэхүүн

Арга хэмжээ

Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь арилжааны зориулалттай эсэх ? Тийм Үгүй

3. Зөвшөөрлийн мэдээлэл:

Хүсэлт нь барааны тэмдгийн төлбөрт нөхцөлд хамаарах эсэх ? Тийм Үгүй

Хүсэлтийг зөвшөөрсөн эсэх ? Тийм Үгүй

Шийдвэрийн талаарх нэмэлт, мэдэгдэл: _____ Огноо: _____

Гарын үсэг, тамга: _____ /Албан тушаал, нэр/

Мэдэгдэл:

Энэхүү хүсэлт нь зөвхөн тухайн бараа, үйлчилгээний хувьд хүчинтэй бөгөөд өөр бусад бараа, үйлчилгээнд ашиглах боломжгүйг анхаарна уу.

МАЯГТ: ЭШ-М007

**ШУТИС-ИЙН БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ ЛИЦЕНЗИЙН ГЭРЭЭ
(ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР)**

Гэрээнд

оролцогч

талууд

А. Лиценз өгөгч тал /бүрэн хаяг/ Б. Лиценз авагч тал / бүрэн хаяг/

1. Энэхүү гэрээг ШУТИС-ийн эзэмших, ашиглах онцгой эрхийг нь эзэмшиж буй дугаар бүхий барааны тэмдгийг ашиглах лиценз авах хүсэлтийг харгалzan ШУТИС-ийн барааны тэмдгийг ашиглах журмыг удирдлага болгож дараах зүйлүүдийн нөхцөлийг хэлэлцэн тохиролцсон.
2. Лиценз өгөгч тал нь энэхүү лицензтэй холбоотой байгууллагын нэр хүнд, туршлага, техникийн баримт бичиг, мэргэжлийн мэдлэгийг эзэмшиж байгаа болно.
3. Энэхүү лицензийн гэрээ нь зөвхөн гэрээгээр ашиглахаар тохиролцсон барааны тэмдгийг гэрээнд заасан хугацаанд тогтсон нөхцөлийн дагуу ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба борлуулахад хамаарна.



4. Лицензийн гэрээнд баримтлах үндсэн зарчмууд:

4.1 Барааны тэмдгийг хүчинтэй, эрхийн зөрчилгүй байлгах, хүчингүй болгох үйлдэл хийгээгүй буюу хийхгүй байх үүргийг лиценз өгөгч хулээнэ. Хэрэв лиценз өгөгч барааны тэмдгийг хүчинтэй байлгаж чадахгүй болох тэр тухайгаа патент хүчингүй болгох хугацаанаас 6 сарын өмнө лиценз авагчид мэдэгдэнэ. Лиценз авагч барааны тэмдгийг хүчинтэй байлгах нь шаардлагатай гэж үзвэл холбогдох арга хэмжээг авна

4.2.Барааны тэмдэгтэй холбогдох эрхийг гуравдагч этгээдээс зөрчвэл гэрээний талууд харилцан мэдээлж зөрчлийг зогсоож хохирлыг арилгуулах арга хэмжээг хамтран авч ажиллана.

4.3 Урьд нь гуравдагч этгээдэд лиценз...../ өгсөн өгөөгүй/ гэдгээ лиценз өгөгч нотолж байна.

4.4 Талууд энэхүү гэрээний дагуу харилцан шилжүүлсэн баримт бичиг, мэдээлэл, гэрээний нууцыг чанд хадгалж, негеө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд нууцыг мэдээлэхгүй.

4.5 Энэхүү гэрээг хэргэжүүлэх явцад талуудын хооронд маргаан гарвал

А. харилцан хэлцлийн замаар тохиролцоно.

Б. шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

4.6 Лиценз өгөгч гэрээнд заасан барааны тэмдгийг үйлдвэрлэлд ашиглах нөхцөл, гарч болох үр ашгийн талаар баталгаа гаргахгүй.

4.7 Барааны тэмдийг ашигласан бүтээгдэхүүний чанарын шалгалтыг гэрээний талууд 6 сар тутамд хамтран хийж байна. Гарсан зөрчлийг тухай бүрд нь шуурхай арилгаж байна.

5.Гэрээний талуудын хүлээх хариуцлага, онцгой үүрэг

5.1 Лиценз авагч, лиценз өгөгчийн тавьсан шаардлага нөхцөлийг чанд барьж сайн чанарын бүтээгдэхүүн гаргана.

5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйгээс болон гэрээний хугацааг зөрчиснөөс нэг талдаа эд хөрнөгийн хохирол учруулбал үүргээ гүйцэтгээгүй тал бүрэн нөхөж төлбөр төлж байна.

5.3 Зөрчлөөс үүсэх хохирлын төлбөрийн дээд хэмжээ нь жилийн төлбөрийн дээд хэмжээнээс хэтрэхгүй байхаар харилцан тохиролцов.

6. Техникийн баримт бичгийг шилжүүлэх

6.1 Лицензийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, технологийг ашиглахад шаардлагатай техникийн баримт бичгийг хавсралт. Жагсаасны дагуу лиценз өгөгчөөс лиценз авагчид гэрээ хүчин төгөлдөр болохоос нэг сарын өмнө шилжүүлнэ.

6.2 Техникийн баримт бичгийг үнэн зөв, үйлдвэрлэл шууд явуулахад боломжтой бүрэн ойлгомжтой үйлдэгдсэн байхыг лиценз өгөгч хариуцна.

6.3 Техникийн баримт бичгийг дутуу буюу зөрчилтэй байвал лиценз авагч албан ёсны хүсэлт гарган лиценз өгөгчөөс гүйцээн шилжүүлж авахаар тохиров.

6.4 Техникийн баримт бичгийг бүрэн эхээр нь нэг хувийг тусгай төлбөртэйгээр шилжүүлэв.

7.Гэрээний төлбөр

7.1 Лиценз авагч нь барааны тэмдгийг ашигласны төлбөрийг лиценз өгөгчид төлнэ.

7.2 Лицензийн төлбөрийг лиценз өгөгчийн дахь банкны тоот дансанд шилжүүлнэ.

7.3 Аливаа төлбөрийн хэмжээг гэрээний талууд харилцан тохиролцож шийдвэрлэснээс хойш нэг сарын дотор төлбөрийг шилжүүлсэн байна.

Хугацаа хоцорсон хоног тутамд төлбөрийн хувиар тооцож тorgууль хүлээж байхаар тохиров.

7.4 Лицензээр ашиглах гэж байгаа барааны тэмдгийн үнэт чанар, төрөл, ашиглах хэлбэр, үйлдвэрлэлийн хэмжээ, тооцоологдож байгаа эдийн засгийн үр ашиг, бодит орлогыг харгалзан лиценз авагчийн үйлдвэрлэлт, борлуулалтаас жил тутамд олох.....ын..... хувьтай тэнцэх хэмжээний шимтгэлт төлбөрийг лиценз авагч лиценз өгөгчид жил бүр төлөхөөр тохиров.



7.5 Лицензийн төлбөрийг.....улсын мөнгөөртөлнө. Лиценз авагч орлого, ашгаа лиценз өгөгчид үнэн зөв мэдээлнэ. Лиценз авагчийн орлогод хяналт тавих төлөөлгчийг лиценз өгөгч тохиролцожажилтай овогтой -г томилон ажиллуулах боллоо.

8. Гэрээг хүчингүй болгох нөхцөлүүд:

- 8.1 Аль нэг талын санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 8.2 Лицензийн гэрээ хийж байгаа барааны тэмдэг нь үйлдвэрлэлд ашиглах бололцоогүй бол гэрээний талууд гэрээг цуулана.
 - 8.3 Лиценз авагч зохих төлбөрийг лиценз өгөгчид заасан хугацаанд удаа дараа төлөхгүй буюу төлбөрийн чадваргүй байвал гэрээг цуцлана.
 - 8.4 Аль нэг тал нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу гэрээнд заагаагүй үйлдлийг хийж хүндрэл учруулах, гэрээний нөхцлийг зөрчих тохиолдолд гэрээг цуцлана. Энэ тохиолдолд буруутай талдаа бичгээр мэдэгдэл өгч асуудлыг шийдвэрлэнэ.
 - 8.5 Гэрээг цаашид үргэлжлүүлэхэд аль нэг талдаа ашиггүй нь нотлогдвол гэрээг цуцалж болно.
 - 8.6 Лицензийн гэрээний нууцыг негеө талын зөвшөөрөлгүй турдавдагч этгээдэд задруулбал гэрээг цуцлана.
- 9. Гэрээг хүчин төгөлдөр болгох, харгалзах зүйлс**
- 9.1 Энэхүү гэрээ нь Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.
 - 9.2 Гэрээ нь гэрээний талууд гарын үсэг зурж техникийн баримт бичгийг лиценз өгөгчээс лиценз авагчид бүрэн шилжүүлж, оюуны өмчийн газарт бүртгүүлж улсын бүртгэлийн дугаар авсан..... оны.....сарын.....өдрөөс эхлэн оны ... сарын ... өдрийг дуустал ...жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Шаардлагатай гэж үзвэл гэрээний хугацааг дуусахаас 6 сарын өмнө гэрээний талууд харилцан тохиролцож гэрээг үргэлжлүүлэхээр хугацааг сунгаж байхаар тохиролцож гэрээг байгуулав.
 - 9.3 Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдох бүх хураамж, татварыг гэрээний талууд тэнцүү гаргана.
 - 9.4 Энэхүү гэрээнд хавсррагдсан тусгай гэрээ, бусад баримт бичгүүд гэрээний салшгүй хэсэг болно. Хэрэв үүнийг гэрээний аль нэг тал нь үрэгдүүлэх, засварлах, бусдад шилжүүлэх тохиолдолд гэрээг хүчингүй болсонд тооцно.

Лиценз өгөгч талыг төлөөлж

Хаяг

.....

Нэр.....

Утас.....

/гарын үсэг/
/тэмдэг/

Лиценз өгөгч талыг төлөөлж

Хаяг

.....

Нэр.....

Утас.....

/гарын үсэг/
/тэмдэг/



МАЯГТ: ЭШ-М008

БАРААНЫ ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН БҮРТГЭЛ

№	Хүсэлт гаргагчийн нэр	Хүсэлтийн огноо	Хүсэлтийн тодорхойлолт	Шийдвэрлэсэн байдал	Шийдвэрлэсэн огноо	Зөвшөөрөөгүй бол шалтгаан
1	2	3	4	5	6	7